

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН “СҮЛД” ЧУУЛГА

2023 оны 06 дугаар сарын 12

Улаанбаатар хот

“СҮЛД” ЧУУЛГЫН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн зорилт, шалгуур үзүүлэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны А/01 дүгээр тушаалаар баталсан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн зорилт, шалгуур үзүүлэлт, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан Сүлд чуулгын 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 29 заалттайгаар боловсруулан ЦЕГ-ын ЗУГ-ын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Уран сайхны зөвлөл Сүлд чуулгаас 2023 онд хийж гүйцэтгэх уран бүтээлийн календарчилсан төлөвлөгөө, тус чуулгаас 2023 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалтыг гарган чуулгын даргаар батлуулан ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн харилцааг зохицуулахдаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн баримтжуулах зорилгоор удирдлага зохион байгуулалтын А-5, хүний нөөцийн чиглэлээр Б-47, нийт 47 тушаал гаргаж, тус чуулгын үйл ажиллагаа, алба хаагчдын сахилга ёс зүй, ажлын хариуцлага, үүрэг гүйцэтгэлтэй холбоотой, цаг үеийн шинжтэй даргаас 28 удаагийн 769 үүрэг, ажлын чиглэл өгч, хэрэгжилт, үр дүнг тооцон ажилласан.

2023 оны I улиралд чуулгын даргын зөвлөлийн хурлыг 7 удаа зохион байгуулж удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр 11, хүний нөөцийн чиглэлээр 29 асуудлыг хэлэлцэж, гарсан шийдвэрийг тухай бүр алба хаагчдад мэдээлж ажиллав.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан загварын дагуу зохион байгуулалтын нэгжийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, мөн тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан загварын дагуу албан тушаалын тодорхойлолттой уялдуулан нийт 54 алба хаагч /14 офицер, 40 ахлагч/ төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Хоёр. Дээд шатны байгууллага, албан тушаалтнаас
өгсөн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, албан
даалгаврыг хэрэгжүүлэх талаар

Тайлант хугацаанд шинээр баталсан, нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомж, төрийн болон байгууллагын бодлого чиглэл, үйл ажиллагаатай холбоотой шийдвэр, удирдах байгууллагаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл, чуулгын болон алба хаагчдын үйл ажиллагаа, цаг үеийн нөхцөл байдал, бодлогын баримт бичиг тусгагдсан болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах, мэдээлэл хүргэхтэй холбоотойгоор Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, алба, нэгжээс эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн нийт 68 удаагийн мэдээллийг давхардсан тоогоор 985 алба хаагчид мэдээлж, хэрэгжилтийг хангаж ажилласан.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, алба хаагчдад тулгамдаж буй асуудлын талаарх санал сэтгэгдлийг авах, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор үүсгэсэн “Алба хаагчдын чөлөөт индэр” цахим хаалттай бүлэгт чуулгын алба хаагчид бүрэн нэгдэж, 16 удаагийн шууд дамжуулалтад хамрагдан санал бодлоо илэрхийлсэн.

Чуулгын офицер бүрэлдэхүүнээс өдөр бүр ерөнхий эргүүлийн үүрэг гүйцэтгэж, чуулгын даргаас өгсөн үүргийн дагуу рапортын дэвтэрт чуулгын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 1-3 санал бичиж хэвшсэн. Эхний хагас жилийн байдлаар 98 санал, санаачлага гаргаж, холбогдох алба хаагчид хариуцуулан өгч биелэлтийг хангасан.

Гурав. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн талаар

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/53 дугаар "Сүлд чуулгын албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэх батлах тухай" тушаалын хүрээнд /офицер 16, ахлагч 46, энгийн 11/ нийт 73 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр батлагдсан боловч 2023 оны 06 дугаар сарын байдлаар 62 /офицер-1, цагдаа-8, энгийн-2 орон тоо дутуу/ алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.

Тус чуулгын орон тооны нөхөн хангалтыг хийх зорилгоор төрийн албаны нөөцөд байсан 1 иргэнийг судалж бүжигчний албан тушаалын орон тоонд чуулгын даргын тушаалаар томилгоожуулж, хүний нөөцийн бодлогыг ил тод байлгах зорилгоор бусад сул орон тооны зарыг www.unegui.mn, “Цагдаагийн СҮЛД чуулга” фэйсбүүк пэйж хаяг, www.suld.police.gov.mn албан ёсны хаягт байршуулж, ажиллах хүсэлт гаргасан 14 иргэнээс сонгон шалгаруулалтыг дотооддоо зохион байгуулж, шалгарсан хөгжимчин 2, бүжигчин 3, нярав 1, бүжгийн багш 1 нийт 7 иргэнийг Төрийн албаны салбар зөвлөлийн “Цагдаа” мэргэжил олгох сонгон шалгаруулалтад оролцуулж, нөөцөд бүртгүүлж, Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуулийн “Цагдаа” мэргэжил олгох сургалтад хамруулж, томилуулах саналыг холбогдох газарт хүргүүлээд байна.

2023 онд шинээр томилогдсон нярав Г.Мөнхжаргал, бүжигчин Д.Долгормаа, Э.Улсболд, Д.Бямбажаргал, шилжиж ирсэн Я.Эрдэнэбат, Э.Гантөмөр нарт чуулгын даргын тушаалаар халамжлан сургах багшийг томилж, ажлын байранд богино хугацаанд дасан зохицох хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан “Алба хаах” болон “Итгэлцлийн” гэрээг байгуулж ажилласан.

Алба хаагчдаас албан тушаал дэвшүүлэх тохиолдолд чадахуйн зарчим /мерит/-ын зорилтыг хангаж 2022 оны албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгэгдсэн цагдаагийн хошууч А.Эрдэнэцэцэгийг Захиргааны удирдлагын тасгийн даргаар, Хөгжмийн хэсгийн хөгжимчин, цагдаагийн ахлагч М.Гимлайнамбарыг хөгжмийн хэсгийн ахлагчийн орон тоонд тус тус дэвшүүлэн томилуулсан.

Чуулгын алба хаагчдын цалингийн зэрэглэл, тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл, онцгой нөхцөлийн нэмэгдэл, орон тооны дэлгэрэнгүй судалгаа, шагнал, цол, ажилласан жилийн судалгаа, цахим хаягийн бүртгэл, алба хаагчдын гэрийн хаягийн бүртгэл, 2023-2024 онд тэтгэвэрт гарах алба хаагчдын судалгаа, ахмад ажилтны судалгаа, хүүхдийн судалгааг гаргаж, 2022 онд тус чуулгаас гарсан нийт 10 иргэний материалыг “Архив ,албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”, Байгууллагын архивын ажлын үндсэн зааварт заасны дагуу бүртгэн, тус бүрийг товъёогжуулж 10 ширхэг хадгаламжийн нэгж үүсгэн бичиг хэргийн эрхлэгч, архивчид хүлээлгэн өгсөн.

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн баярын өдрүүдийг тохиолдуулан Сүлд чуулгын даргын “Баярын бичиг”-ээр 2, Баянзүрх дүүргийн Засаг даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр 1, мөн дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын “Өргөмжлөл”-өөр 1, Дотоодын цэргийн штабын 100 жилийн ойн медалиар 2, Монголын

залуучуудын холбооны 100 жилийн медалиар 5, Монголын эмэгтэйчүүдийн холбооны “Хүндэт тэмдэг”-ээр 1, Сонигонхайрхан дүүргийн Засаг даргын “Хүндэт тэмдэг”-ээр 1 алба хаагчийг тус тус шагнаж, урамшуулан ажилласан.

Мөн Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 102 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын төрийн одон медаль “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон” 1, “Хөдөлмөрийн хүндэт медаль” 1, “Алтангадас одон” 1, “Цэргийн хүндэт медаль”-иар 4 алба хаагчийг, Цагдаагийн Ерөнхий газрын шагнал “Цагдаагийн гавьяа” тэмдгээр 4, “Хүндэт жүүх” бичгээр 1 алба хаагч, “Албаны төлөө 2” медалиар 2 алба хаагчийг; Монгол Улсын Соёлын яамны “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдгээр 1 алба хаагчийг тус тус шагнуулахаар санал, холбогдох материалыг хүргүүлсэн.

Шинээр цагдаа албан тушаалд томилогдсон 4 алба хаагчид албаны А серийн үнэмлэх, энгэрийн тэмдэг олгуулж, албанаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 4, албанаас халагдсан 1 алба хаагчдад тооцооны хуудас олгож, орсон, гарсан хөдөлгөөнийг тухай бүр хийн хүний нөөцийн цахим санд оруулж архивын нэгж болгон хадгалсан байна.

Алба хаагчдын ажилласан жилийг тооцон цалингийн сүлжээ шатлалын дагуу тухай бүрд нь тогтоож баталгаажуулан хэвшсэн бөгөөд 2023 оны 06 дугаар сард нийт 11 алба хаагч, 11 ажилтны цалингийн шатлал, төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг тооцон удирдлагад танилцуулан баталгаажуулж, Цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээ /system.police.gov/-нд байрлах хүний нөөцийн цахим санд мэдээллийг шинэчилсэн.

Мөн “Төрийн албаны тухай хууль”-ийн 60 дугаар зүйлийн 60.1-д заасны дагуу цэргийн алба хаасны байнгын тэтгэвэрт гарсан 3 ахмад ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж олгож өгөх хүсэлтийг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба, Хүний нөөцийн хэлтэст хүргүүлж, 2 ахмад ажилтны 36 сарын тэтгэмжийг олгуулсан.

Дөрөв. Өргөдөл, гомдол хүлээн авах,
шийдвэрлэлтийн талаар

Цагдаагийн байгууллагын албан ёсны /service.police.gov.mn/ цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл байгаа эсэхэд хяналт тавих, иргэдийг ялгаварлан гадуурхахгүй, ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр 2023 оны 1, 2, 3, 4, 5, 6 дугаар сарын байдлаар нийт 42 өргөдөл ирсэнээс ажилд орохыг хүссэн 11, ажил өөрчлөх, шилжихийг хүссэн 6, захиргааны чөлөө хүссэн 14, бусад 21, хугацаанд нь шийдвэрлэсэн 42 өргөдөл гомдол бүртгэгдсэнийг бүрэн шийдвэрлэж, мэдээг сар бүр Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хүргүүлсэн.

Тав. Архив, албан хэрэг хөтлөлт,
бичиг хэргийн талаар

Албан хэрэг хөтлөлтийн журам, зааврын дагуу хөтлөгдвөл зохих бүртгэлийн “Ирүүлсэн албан бичиг /хариутай, хариугүй/, “Явуулсан албан бичиг”, “Удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн танилцуулга”, “Удирдах дээд шатны байгууллагаас ирүүлсэн албан бичиг”, “Өргөдөл гомдлын бүртгэлийн дэвтэр”, “Тушаалын бүртгэлийн дэвтэр” зэрэг 7 дэвтрийг хөтлөн чуулгын үйл ажиллагаанд өдөр тутам үүсч, хөтлөгдөж буй баримт бичгийн стандарт, зөв бичих дүрэм, Монгол хэлний найруулга зүйн алдаагүй боловсруулахад анхаарч, төслийг удирдах ажилтанд хянуулан, гарын үсгээр баталгаажуулсны дараа хэвлэмэл хуудсанд хэвлэж хэвшсэн.

2023 оны 01 дүгээр улиралд чуулгын архивын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 2022 оны ирсэн 8, явсан 6, А, Б тушаалууд зэргийг архивлаж бэлэн болгосон.

Чуулгын архивын 2018 оны 15 ширхэг байнга хадгалах хадгаламжийн нэгжийг Төв архивын газарт хүргүүлсэн.

Чуулгын 2022 оны Хөтлөх нэрийн жагсаалтыг боловсруулан Төв архивын газарт хянуулахаар хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын газраас 2023 оны 03 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулсан архивын ажилтнуудын мэргэшүүлэх 2 өдрийн сургалтад тус чуулгын бичиг хэргийн ажилтан хамрагдаж сертификат авсан.

2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Төв архивын газраас ирүүлсэн баримт шилжүүлэн хүлээн авах тухай албан бичгийн дагуу чуулгын архивт хадгалах хугацаа дууссан 51 ширхэг байнга хадгалах, боловсон хүчний материалуудыг Төв архивын газарт хүлээлгэн өгсөн.

Зургаа. Сахилга хариуцлага, ёс зүйг сайжруулах чиглэлээр

Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст сахилга, хариуцлага, мөн газрын Төлөвлөлт зохион байгуулалтын хэлтэст өргөдөл гомдлын мэдээг албан бичгээр тус тус хүргүүлж ажилласан. Өнөөдрийн байдлаар тус чуулгын алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчилд холбогдсон алба хаагч болон иргэд, байгууллагаас алба хаагчдад холбогдуулан гаргасан өргөдөл, гомдол байхгүй болно.

2023 оны 05 дугаар сард сахилга, ёс зүйн зөрчил гаргасан 2 алба хаагч, 1 ажилтанд албаны шалгалт явуулснаар хагас жилийн байдлаар 2 алба хаагч, 1 ажилтанд 1 удаагийн тушаалаар албан тушаалын үндсэн цалинг 3 сар 20 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан байна. Сахилга ёс зүйн зөрчил гаргасан, албаны шалгалт хийгдэж, арга хэмжээ тооцогдсон алба хаагчдаас гэмт хэрэг, сахилга ёс зүйн зөрчилд дахин өртөхөөс урьдчилан сэргийлэх баталгааг авч ажилласан.

Долоо. Албаны сургалт,
сургалт, соён гэгээрүүлэх ажлын талаар

Албаны сургалтын чиглэлээр: Тус чуулга нь Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2023 оны А/46 дугаар тушаалаар баталсан “Албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-ний дагуу 2023 онд мэдвэл зохих хууль тогтоомжийн 16 сэдвээр 32 цаг, алба хаагчийг хөгжүүлэх 9 сэдвээр 18 цаг, дадлагажуулах 4 сэдвээр 8 цаг, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг хангах 2 сэдвээр 14 цаг, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 2 сэдвээр 50 цагийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн чуулгын даргаар батлуулснаас 2023 оны эхний хагас жилд нийт 37 удаагийн 60 цагийн сургалтад давхардсан тоогоор 2264 алба хаагч хамрагдаж, мэдвэл зохих хууль тогтоомжийн 17 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1044 алба хаагч, алба хаагчийг хөгжүүлэх 12 удаагийн сургалтад 734 алба хаагч, дадлагажуулах 3 удаагийн сургалтад 183, бие бялдрын бэлтгэлжилтийн 5 удаагийн сургалтад 303 алба хаагч давхардсан тоогоор тус тус хамрагдаж, танхимын сургалт 7, дадлагын сургалт 7, зайн болон цахим сургалт 23 удаа зохион байгуулсан байна.

Чуулгын алба хаагчдын дунд 2023 онд зохион байгуулах албаны сургалтын төлөвлөгөөг батлуулах ажлын хүрээнд алба хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлага, төлөвлөгөөнд тусгах саналыг авах зорилгоор цахим санал асуулгыг явуулж дүнг нэгтгэлээ. Санал асуулгад 35 алба хаагч хамрагдсан бөгөөд гарсан саналыг 2023 оны албаны сургалтын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Чуулгын алба хаагчдыг мэдээллээр тасралтгүй хангах ажлын хүрээнд удирдах дээд шатны байгууллагаас ирүүлсэн 78 үүрэг ажлын чиглэлийг чуулгын дарга, тасгийн дарга

биечлэн болон “Сүлд цахим тайз” хаалттай фейсбүүк группт байршуулж, 2023 оны эхний хагас жилд 6 удаа зохион байгуулсан чуулгын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал гарсан шийдвэрийг тухай бүр алба хаагчдад мэдээлж ирэв.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны А/73 дугаар тушаалаар зохион байгуулагдсан сургалт хариуцсан алба хаагчдын мэдлэг, үр чадварыг нэмэгдүүлэх 2 өдрийн сургалт, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын дунд зохион байгуулагдах “Бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэг”-ийн дүнг нэгтгэх программ, сургалтын Gosmart динамик флатпормд ажиллах арга зүйн сургалтад соён гэгээрүүлэх, албаны сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн хамрагдсан.

Алба хаагчдын илтгэх үр чадварыг дээшлүүлэх, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор чуулгын нийт алба хаагч, ажилтнууд хууль тогтоомж, төрийн болон байгууллагын бодлого чиглэл, үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, улс орны болон гадаад орнуудын улс төр, нийгэм, эдийн засаг болон танин мэдэхүйн бусад мэдээлэл, түүхэн замнал, шинжлэх ухаан, техник, технологийн ололтын талаарх мэдээллээс сонгож бэлтгэн 3-5 минутын хугацаанд нийт бие бүрэлдэхүүнд мэдээлэл хийх хуваарийг баталж, хэрэгжүүлж байна. Мэдээллийг эхний улиралд нийт 24 алба хаагч хийж, давхардсан тоогоор 1140 алба хаагч давхардсан тоогоор хамрагдсан байна.

Филиппин улсад англи хэлний сургалтад хамруулах шагнал бүхий “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд миний гүйцэтгэх үүрэг” сэдэвт эсээ бичлэгийн уралдаанд тус чуулгын 22 алба хаагч оролцож, эсээг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 25/95 дугаартай албан бичгээр хугацаанд нь хүргүүлэв.

Уралдааны хүрээнд “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого сэдэвт танхимын сургалтыг чуулгын дарга зохион байгуулж, алба хаагчдыг эсээ бичихэд шаардлагатай тодорхой ойлголтыг өгсөн.

“Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэг”-ийг байгууллагын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, нэгдүгээр шатны шалгалтыг 03 дугаар сарын 20-ны өдөр алба хаагчдаас авч ажилласан. Үүнтэй холбогдуулан алба хаагчдад “Бие бялдрын бэлтгэлжилтийн норматив, стандартын харьцуулалт” сэдэвт цахим сургалтыг зохион байгуулав.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн энэ оны А/42 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ыг хэрэгжүүлэх, алба хаагчдыг сурган дадлагажуулах сургалтад чуулгын бие бүрэлдэхүүн хамрагдсан.

Уг сургалтын дараах шалгалтад 43 алба хаагч хамрагдсанаас биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх чадварын шалгалтад 6 алба хаагч 90% буюу “А”, 37 алба хаагч 70% буюу “С”, үнэлэгдэж, хууль, эрх зүйн мэдлэгийн шалгалтад 13 алба хаагч “А”, 15 алба хаагч “В”, 9 алба хаагч “С”, 6 алба хаагч “D” үнэлэгдсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Албан тушаал шатлан дэвшүүлэх багц сургалтад хамруулах шалгалт авах, нөөцөд дэвшүүлэн томилох” /Код/-909, 909.4.2-т заасны дагуу чуулгаас ахлах албан тушаалын нөөцөд 1, офицерын нөөцөд 3 алба хаагч бүртгүүлэхээр материалаа хүргүүлж, сургалтад бүрэн хамрагдаж, шалгалтаа өгч тэнцэн нөөцөд бүртгэгдсэн.

Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын баталсан төлөвлөгөө, хуваарийн дагуу Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын Эрүүл мэнд, сэтгэл зүйн хэсгийн ахлах сэтгэл зүйч,

цагдаагийн хошууч Э.Бямбажаргалаар ахлуулсан сэтгэл зүйчдийн баг чуулгын алба хаагчдаас зан төлөвийн судалгааг авч, “Дадал” сэдэвт хичээл орж, 2 алба хаагч сэтгэл зүйчтэй ганцаарчлан уулзаж, зөвлөгөө авсан.

Мөн цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сэтгэл зүйчдийн бэлтгэн ирүүлсэн видео хичээлүүдийг чуулгын цахим хаалттай бүлэгт байршуулан судлуулж, тэмдэглэл хөтлүүлсэн. Үүнд: Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын сэтгэл зүйч М.Агиймаа “Гэр бүлийн гишүүдийн үүргийн хэм хэмжээ ба түүний ач холбогдол”, Орхон аймгийн цагдаагийн газрын сэтгэл зүйч цагдаагийн дэслэгч Т.Уранбилэг “Хөдөлмөрийн орчин нөхцөл сэтгэл зүйд нөлөөлөх нь”, Баянхонгор аймгийн цагдаагийн газрын сэтгэл зүйч Д.Хоролгарав “Зорилго ба амжилт”, Хар тамхитай тэмцэх газрын сэтгэл зүйч цагдаагийн дэслэгч н.Сумъяасүрэн “Эрчүүдийн сэтгэл гутрал түүнийг даван туулах нь”, Дотоодын цэргийн 05 дугаар ангийн сэтгэл зүйч О.Энхмарал “Алба хаагчдын хандлага, түүнийг сайжруулах нь” зэрэг сэдвээр хичээл бэлтгэн ирүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын даргаас ирүүлсэн 2023 оны 01 дүгээр сарын 11-ний 6/367 дугаартай албан бичгийн хүрээнд Хүч спорт хорооны сургалтын танхимд зохион байгуулсан “Амь тэнссэн үеийн амилуулах суурь тусламж” сэдэвт 1 цагийн лекц, 1 цагийн дадлагын сургалтад алба хаагчдыг хамруулав.

Сургалтыг Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын хөдөлмөрийн аюулгүй байдлын байцаагч, их эмч, цагдаагийн дэслэгч Б.Бямбацогт, НЦУГ-ын Эрүүлжүүлэн саатуулах төвийн жижүүрийн эмч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Чойндонжамц нар удирдан явуулж амилуулах суурь тусламжийн үндсэн ойлголт, аргачлал, анхаарах асуудлын талаар ойлголт, мэдлэгийг дээшлүүллээ.

Чуулгын алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор мэдвэл зохих дүрэм, журмыг судлуулах ажлыг зохион байгууллаа.

Энэ ажлын хүрээнд ЦАТХ-д заасан тодорхой ажиллагаа явуулах эрх зүй, шинэчлэн баталсан цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрмийг үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд анхаарах асуудал зэрэг цахим сургалтыг цахим группт байршуулан судлуулав.

Түүнчлэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 401 “Эргүүлийн үүрэг гүйцэтгэх”, 400 “Цагдаагийн эргүүл, харуулын дүрмийг хэрэгжүүлэх”, 914 “Сахилгын шийтгэл оногдуулах”, 909 “Албан тушаал шатлан дэвшүүлэх багц сургалтад хамруулах, шалгалт авах, нөөцөд бүртгэх, дэвшүүлэн томилох”, 917 “Дүрэмт хувцас өмсөж хэрэглэх”, 928 “Ажлын бус цагаар өөр ажил эрхлэх”, 937 “Алба хаагч үндсэн эрхээ эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандах”, 923 “Албан газар, албаны тээврийн хэрэгсэл дотор тамхи татахыг хориглох”, 921 “Албан үүрэг гүйцэтгэх үед алба хаагч хүнтэй харилцах, биеэ авч явах байдал”, 934 “Алба хаагчид чөлөө олгох”, 940 “Соёл, соён гэгээрүүлэх ажил” зэрэг алба хаагчдын чиг үүрэгтэй холбоотой, мэдвэл зохих 13 дүрэм, журам бүхий 45 ширхэг товхимол бэлтгэн хэвлэж алба хаагч тус бүрд тараан судлуулав.

Мэдлэг, ойлголтыг бататгах зорилгоор 60 асуулт бүхий цахим шалгалтыг зохион байгуулж, 41 алба хаагч хамрагдсан.

Чуулгын дотоод журмыг алба хаагч, ажилтнуудаар судлуулах ажлын хүрээнд хичээл орж, 25 асуулт бүхий тестээр бататгах шалгалтыг цахим хэлбэрээр авч дүгнэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/107 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус чуулгын алба хаагчдад Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах

хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад О.Баярсайхан, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Эргүүл хамгаалалтын газрын Эргүүл, тусгай хамгаалалтын хэлтсийн эргүүл хамгаалалтын офицер, цагдаагийн ахлах дэслэгч А.Нарантуяа, Баянгол дүүргийн цагдаагийн газрын Хэв журмын ажил хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч О.Нямдорж нар “Хүний эрхийн тухай ойлголт, үндсэн зарчим, хязгаарлалт”, “Жагсаал цуглааны үед хүний эрхийг хангах”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх” зэрэг сэдвээр давтан сургалтыг зохион байгууллаа.

Чуулгын даргаас өгсөн үүргийн хэрэгжилтийг хангах чиглэлээр алба хаагчдын цэрэгжилч, жагсаалч байдлыг сайжруулах, цэргийн жагсаалын дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 14 хоногт 1 удаа жагсаалын бэлтгэл хийх хуваарь гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд жагсаалын бэлтгэлийг ДХИС-ийн Ахлагчийн сургуулийн дамжааны захирагч, цагдаагийн ахмад Б.Батсүрэнг урьж сургалт хийлгэсэн.

Цагдаа, Дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2023 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бие бялдрын хөгжил, дасгал хөдөлгөөний “Сургагч багш” бэлтгэх сургалтыг 5 дугаар сарын 17, 18-ны өдөр Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвтэй хамтарч зохион байгуулав.

"Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын албаны бэлтгэлжилттэй холбоотой хууль, эрх зүйн мэдлэг, бие бялдрын түвшинг дээшлүүлэх хөтөлбөр" -ийн хэрэгжилтийг хангах зорилгоор чуулгын эмэгтэй алба хаагчид удирдан алба хаагчдад өглөөний дасгал хийлгэх ажлыг эхлүүлсэн бөгөөд 10 удаагийн дасгал хөдөлгөөнд хамруулав.

Мөн чуулгын алба хаагчдын дунд 1 сарын эрчимтэй дасгал хөдөлгөөн, зөв хооллолтын хөтөлбөрийг бүжигчин, цагдаагийн ахлах ахлагч Г.Ууганбаярын дасгалжуулалт дор эхлүүлж, амжилттай явагдаж байна.

Дотоод хэргийн их сургуулийн усан спорт сургалтын төвд 7 хоног бүрийн мягмар гарагт чуулгын алба хаагчид тогтмол хамрагдаж байна.

Стратегийн команд штабын сургуулийн хүрээнд Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран “Гамшгийн үед ажиллах”, “Гал түймрээс урьдчилан сэргийлэх” сэдвүүдээр 2 цагийн сургалт хийж, энэ оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 16:00 цагт орон даяар зохион байгуулсан гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд чуулгын алба хаагчид хамрагдаж, цугларах цэгт цуглаж, гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл авч ажилласан.

Тус чуулгаас Дотоод Хэргийн Их сургуулийн бакалаврын 2023-2024 оны хичээлийн жилийн “Цагдаагийн ажил-Эрх зүй” эчнээ сургалтын 2,3 дугаар дамжаанд 2 алба хаагч, цагдаа бэлтгэх дамжаанд 7 иргэн хамрагдан, Соёл урлагийн Их сургуулийн магистрантурт 1, Монгол Улсын Их сургуулийн докторын сургалтад 2 алба хаагч суралцаж байна.

Соён гэгээрүүлэх чиглэлээр: 2023 оны эхний хагас жилд чуулгын алба хаагчдын дунд нийт 44 удаагийн соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 2627 алба хаагч, ажилтныг хамруулав. Үүнээс мэдээлэл сурталчилгааны 21 ажил, арга хэмжээнд давхардсан тоогоор 1241 алба хаагч, соёл хүмүүжлийн 23 ажилд 1386 алба хаагчийг хамруулан зохион байгуулав.

Удирдах дээд шатны байгууллагаас ирүүлсэн 68 үүрэг ажлын чиглэлийг чуулгын дарга, тасгийн дарга биечлэн болон “Сүлд цахим тайз” хаалттай фейсбүүк группт байршуулж, алба хаагчдыг мэдээллээр хангаж ажиллалаа.

2023 оны эхний хагас жилд “Алба хаагчдын чөлөөт индэр” цахим хаалттай бүлэгт зохион байгуулагдсан 16 удаагийн шууд дамжуулалтад алба хаагчид хамрагдсан.

Тайлант хугацаанд чуулгын даргын зөвлөлийн хурлыг 6 удаа зохион байгуулж хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийг тухай бүр алба хаагчдад мэдээлж ажиллав.

Чуулгын “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-өөс сар бүр нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн, тус зөвлөлөөс санаачлан “Албаны дүрэмт хувцасаараа гоёцгооё” уриан дор албандаа хүндэтгэлтэй хандаж, дүрэмт хувцасаа дүрмийн дагуу өмсөж хэрэглэх 1 сарын аяныг зохион байгуулсан.

Мөн “Хөгжөөнт захидал”, “Хөгжөөнт тэмцээн”, “Дархлаа дэмжье”, “Витаминжуулалтын аян”, “Мартын 18” зэрэг 5 удаагийн ажил арга хэмжээг 300 гаруй алба хаагчийг хамруулан зохиосон байна.

Чуулгын спорт хамтлагаас биеийн тамир, спортын тэмцээн уралдаан зохион байгуулах хуваарь, төлөвлөгөөг гарган чуулгын даргаар батлуулж, нийт 14 тэмцээн уралдааныг зохиохоор хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эхний хагас жилд алба хаагчдын дунд сагсан бөмбөг, гар бөмбөг, боулинг, шагайн харваа, шагай шүүрэх, дартсын аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулж давхардсан тоогоор 360 алба хаагчийг хамруулав.

Цагдаагийн ерөнхий газрын харьяа алба, нэгжүүдийн дунд зохион байгуулсан гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд холимог баг, тамирчид амжилттай оролцож, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын дунд зохион байгуулсан тухай өргөлтийн аварга шалгаруулах тэмцээн, дуатлон, дартсын тэмцээнд тус чуулгаас 20 алба хаагч оролцсон.

Алба хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, амьдралын эрүүл хэвшил дадлыг хэвшүүлэх зорилгоор Хүч спорт хорооны зааланд 7 хоног бүрийн даваа гараг бүр биеийн тамирын бэлтгэл, дасгал хийж, мягмар гараг бүр Дотоод хэргийн их сургуулийн Усан спорт сургалтын төвд алба хаагчид сургалтад хамрагдаж хэвшсэн.

Түүнчлэн Чингис хааны музейг алба хаагч, тэдний гэр бүлд үзүүлэх ажлыг зохион байгуулж, “Анд” хэвлэлийн газартай хамтран чуулгын байранд номын өдөрлөгийг зохион байгуулж, алба хаагчид 20%-ийн хөнгөлөлттэйгээр ном худалдан авах боломжийг бүрдүүлж, алба хаагчдын эрүүл мэндийг дэмжих, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор өглөөний дасгал, эрчимжүүлсэн дасгал хөдөлгөөнийг өдөр бүр хийж хэвшсэн.

Тус чуулгаас цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын дунд МУСГЗ, МЗЭ-ийн шагналт, яруу найрагч, цагдаагийн хурандаа Л.Гаваасүрэн агсны нэрэмжит “Монгол минь амгалан байна” дууны анхдугаар уралдааныг “Л.Гаваасүрэн сан”-тай хамтран хоёр үе шаттай зохион байгуулав.

“Эрүүл аюулгүй –Цэвэр орчин” бүрдүүлэх уриан дор 03 дугаар сарын 31-ний өдөр БЗД-ийн 26 дугаар хороо Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн “Бид мартаггүй” хөшөөний ойр орчимд 50 метр газрын цэвэрлэгээ хийж, хөшөөг угааж ажилласан.

Цагдаагийн Ерөнхий газрын тэргүүн дэд даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 20/273 тоот үүргийн дагуу Цагдаагийн байгууллага, алба хаагчдын нэр хүндийг дээшлүүлэх зорилгоор хийсэн богино хэмжээний видео контентыг 2 дугаар сарын 16-ны өдөр зураг авалт хийж, 2 дугаар сарын 26-ны өдөр чуулгын даргын зааварчилгаагаар эвлүүлгийн засвар сайжруулалтыг хийж 2 дугаар сарын 27-ны өдөр ЦЕГ-ын УСХ-ийн ажлын хэсгийн ахлагч цагдаагийн дэд хурандаа Ц.Нарантуяад хүлээлгэн өгч, 2 дугаар сарын 28-ны

өдөр тус хэлтсийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан орон даяар түгээлт хийгдсэн. Эхний хагас жилийн байдлаар 53478 үзэлттэй байна.

Найм. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах,
мэдээлэл, сурталчилгаа, зохион байгуулсан ажил,
арга хэмжээний талаар

Чуулгын үйл ажиллагааг “Цагдаагийн СҮЛД чуулга” фэйсбүүк пэйж хаяг, www.suld.police.gov.mn албан ёсны цахим хаягаар дамжуулан сурталчилж байгаа бөгөөд 2023 оны хагас жилийн байдлаар чуулгын фэйсбүүк хуудасны нийт дагагчийн тоо 32.500, нийт хандалтын тоо 59473 хүн, нийт чуулгын цахим хуудсанд зочилсон хүний тоо 105.500 хүрсэн байна.

Цахим хуудсыг дагадаг хүмүүсийн 53.7% нь эмэгтэй, 46.3% хувь эрэгтэй бөгөөд 38.5% нь 25-34 насны хүмүүс эзэлж байна. Мөн байршлаар нь авч үзвэл Монгол Улс 79.1%, БНСУ 1%, Япон 0.5%, шинээр нэмэгдсэн 64, хасалт хийсэн 40 тус тус ханджээ.

Чуулгын алба хаагчдын шинэ уран бүтээл 5, тэмдэглэлт баяр ёслолын мэндчилгээ 18, видео контент 5, ажлын зар 5, чуулгын үйл ажиллагааны зурган мэдээ мэдээлэл 59, чуулгын алба хаагчдын төрсөн өдрийн 12 зурагт мэндчилгээ болон тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн постер 68, видео бичлэг 148, Фото зурагт 315 шот чуулгын цахим хуудсанд тус тус байршуулсан.

Сар шинийн баярт зориулсан нэвтрүүлгийг МҮОНРТ-тэй хамтран “Шинэ сарын аялгуу” концертыг олны хүртээл болгосон ба цагдаагийн ахмад уран бүтээлч МУГЖ уртын дуучин Б.Цэвэлмаагийн “Сүлдэнд мөнхөрсөн дуулал” уран бүтээлийн цэнгүүнийг зохион байгуулсан.

“Монгол цэргийн өдөр”-ийг угтан орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл доор зохион байгуулж буй “Цэргийн андууд” дурсамж уулзалт ёслолын арга хэмжээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын музейн үзэсгэлэнгүүд дэлгэгдэж, Цагдаагийн “Сүлд” чуулга, музей болон уран бүтээлүүдээрээ оролцсон.

“Монгол цэргийн өдөр”, Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 102 жилийн ойд зориулан Монголын Залуучуудын Холбооноос санаачлан эх орон, түүх соёлоороо бахархах үзлийг түгээх, цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх, Монгол цэргийн бахархалт түүх, гавьяат үйлсийг залуу хойч үедээ сурталчлан таниулах зорилгоор “ЭХ ОРНЫ ТӨЛӨӨ” Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын харьяа мэргэжлийн урлагийн мөрдөст чуулгуудын нэгдсэн хүндэтгэлийн тоглолтыг 2023 оны 3 дугаар сарын 18-ний өдөр Соёлын төв өргөөнд анх удаагаа амжилттай зохион байгуулсан. Энэхүү хүндэтгэлийн тоглолтод Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулга, Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга, Цагдаагийн ерөнхий газрын “Сүлд” чуулга, ЗХЖШ-ын харьяа Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Соёмбо” чуулгуудын уран бүтээлчид хамтран шилдэг уран бүтээлүүдээрээ оролцсон.

TV25 телевизийн “Урт цагааны гудамж” нэвтрүүлэгт цагдаагийн албаны төлөөлөл болж Цагдаагийн Сүлд чуулгын дуучин дэд ахлагч Э.Адъяасүрэн оролцуулсан.

Мөн дуучин, цагдаагийн ахлагч Р.Эрдэнэболд, цагдаагийн ахлах ахлагч Э.Сүнжидмаа нар NTV телевизийн “Дуун дугараа” шууд нэвтрүүлэгт оролцож ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн.

“МУСГЗ, МЗЭ-ийн шагналт, яруу найрагч, цагдаагийн хурандаа Л.Гаваасүрэн агсны нэрэмжит "МОНГОЛ МИНЬ АМГАЛАН БАЙНА" дууны анхдугаар уралдааныг Л.Гаваасүрэн сан, Цагдаагийн ерөнхий газар, Цагдаагийн Сүлд чуулга хамтран зохион байгууллаа. Уг анхдугаар уралдааныг “МУСГЗ, МЗЭ-ийн шагналт, яруу найрагч, цагдаагийн хурандаа Л.Гаваасүрэн агсны дуу, шүлгийн бүтээлүүдийг олон нийтэд суртчилан таниулах,

алдаршуулах Цагдаа дотоодын цэргийн алба хаагчид, олон нийтийг соён гэгээрүүлэх, албаараа бахархах зэрэг ажлуудын хүрээнд хийж гүйцэтгэсэн.

Тус уралдааныг Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагуудын дунд анхлан зохион байгуулж байгаагаараа онцлог болж уралдаанд Цагдаа дотоодын цэргийн албанаас чөлөөндөө гарсан ахмадууд болон 45 анги байгууллагын 104 алба хаагчид анхдугаар уралдаанд оролцох мэдүүлгээ ирүүлснээс нэгдүгээр шатанд видео хэлбэрээр бичлэгээ иргүүлсэн 64 алба хаагчаас хоёрдугаар шатанд шалгарч үлдсэн 31 алба хаагч шалгарч, Гала тоглолтод шагналт байрт шалгарсан алба хаагчид оролцож тус тоглолтыг ЦЕГ-ын Сүлд чуулгын урлагийн их танхимд 3-р сарын 24 өдөр амжилттай зохион байгуулсан.

ЦДЦБ-ын алба хаагчдын хүүхдүүдэд зориулсан “Хүүхэд таныг хамгаалъя” өдөрлөгийн тоглолтын хөтөлбөр, тоглолтод урилгаар оролцох уран бүтээлчдийн нэрсийг боловсруулж тус арга хэмжээнд амжилттай оролцсон.

Соёлын сэргэлт 2023 аяны арга хэмжээнд Өвөрхангай, Сүхбаатар аймгуудад чуулгын уран бүтээлчдийг оролцуулсан.

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнтэй хамтарч Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2022 оноос хэрэгжиж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллага түүчээлэн оролцож, үхүүлга нөлөөлөл, мэдээлэл сурталчилгааны чиглэлээр “Зөв мод-Зөв арчилгаа”, “Тэрбум мод-Байгалиа бүтээе” зэрэг арга хэмжээний хүрээнд бүх нийтийн мод тарих өдөр болон Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн төлөвлөсөн үйл ажиллагааны хүрээнд мод тарих үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах болон соён гэгээрүүлэх, соёл урлагийн чиглэлээр ажилласан.

Иргэд, олон нийт, шинэ үеийн залуусыг мод тарих, ургуулах, арчлах хандлагад уриалах, шинэ соёлыг төлөвшүүлэх, тэдний экологийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Монголын скаутын холбооны Эко скаут хүүхдүүдтэй хамтран 198 ширхэг модны суулгацыг суулгаж арчлах чиглэлээр санаачилга гарган ажилласан.

Ес. Урлаг соёлын арга хэмжээний талаар

Монголын Урлагийн Ажилтны Холбоо хамтран 2023 оны 1-р улирлаас эхлэн 2023 оны 4-р улирал дуустал хамтран ажиллах саналаа 2023 оны 1 сарын 20 өдөр урьдчилсан байдлаар хүргүүлсэн.

Монгол Улсын Соёлын Яамнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Мөнгөн мод-2022” наадам нь соёлын өв, ном хэвлэл, дуу хөгжим, тайзны урлаг, дүрслэх урлаг, кино урлаг, нийтлэл нэвтрүүлэг, цахим бүтээл, архитектур, хувцас загвар, зар сурталчилгаа, дизайн гэсэн 12 төрлөөр шилдэг бүтээл шалгаруулдаг бол шилдэг уран бүтээлчдийг найруулагч, зураач, зохиолч, хөгжмийн зохиолч, продюсер, удирдаач, бүжиг дэглээч, жүжигчин, хөгжимчин, дуучин, бүжигчин, судлаач гэсэн 12 төрлөөр шалгаруулж, "Мөнгөн мод" цом, мөнгөн шагналаар урамшуулан шагнадаг. Энэ жил 14 дэх удаагийн 2023 оны шилдэг бүтээл, уран бүтээлч шалгаруулах “Мөнгөн Мод-2022” наадамд чуулгаас 7 төрөлд нэр дэвшүүлэх материалуудыг тус тус бэлтгэж цахим бүртгэлийг хугацаанд нь хийж хүлээлгэн өгсөн. Уг наадмаас тус чуулгын бүжгийн багш Ё.Дамчаабадгар нь Монголын анхны үндэсний балет Ж.Чулууны “Уран хас” балетын хөгжмийн зохиолыг нь албан ёсны зөвшөөрөл авч электрон хөгжмийн дуугаралт ашиглан шинэ дэглэлт, найруулгаар 2022 онд шинэчлэн тавьж уг бүтээлээрээ "Шилдэг бүжиг дэглээч" шагнал хүртсэн.

Соёлын яамнаас соёл, урлагийг хөгжүүлэх, сурталчлан таниулах, соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Соёл, урлагийг дэмжих сангаас 2023 онд санхүүжүүлэх төслийн сонгон шалгаруулалтад найруулагч С.Баярсайхны “Нөхөрлөл ба итгэл” төслийн материал бэлтгэж цахим бүртгэлийг хугацаанд нь хийж хүлээлгэн өгсөн боловч энэ жилийн сонгон шалгаруулалтанд тэнцээгүй.

Үлээвэр найрал хөгжмийн ерөнхий удирдаач, цагдаагийн дэслэгч С.Төрбат, Хөгжмийн багш удирдаач, цагдаагийн хошууч Э.Батбаяр нар хуучин болон шинэ зохиолууд,

дууны бүтээлүүдийн бэлтгэл сургуулилтыг хийж ажилласан. Үүнд: Монгол төрийн цагдаа, Buckjump, Аминаас үнэтэй тангараг, Выходной марш, What a wonderful world, Smoke on the water, Uptown funk, I Dreamed Dream, Орос дууны попури, 60-70 оны дууны попури, Хилчин, No moon at all гэх мэт.

Дууны хэсгийн алба хаагчдаас шинэ болон, сэргээж хийсэн уран бүтээлүүдээс танилцуулвал.

- Дуучин цагдаагийн ахлах дэслэгч Г.Дарханбаатар нь , Н.Эрдэнэбат шүлэг МУСТА Р. Билэгт Аялгуу **“Шонхорууд минь”**, **“Аав нь итгэдэг”**
- Дуучин цагдаагийн дэд ахлагч Т. Санжаа Шүлэг , Аялгуу Б.Хүрэлбаатарын **“Тэнгэрийн борхон бялзуухай”** ,
- Дуучин цагдаагийн ахлах ахлагч Э.Сүнжидмаа , **“Цэцэгчний хүслэн”**
 - Дуучин цагдаагийн ахлах ахлагч Э.Нямхүү, **“Гэргий ээж”**
 - Дуучин цагдаагийн ахлагч Л.Эрдэнэболд МАУД **“Сийлэн бөөр”**
 - Дуучин цагдаагийн дэд ахлагч Г.Сувд-эрдэнэ, **“Анирхуйн дуу”**
 - Дуучин цагдаагийн дэд ахлагч Ж.Хулан ” Шүлэг аялгуу Н. Дөлгөөннарэн **“Дурсамж”** зэрэг уран бүтээлүүдийг хийсэн байна.

Сонгодог бүжгийн дасгалын 7 оролтын 14 цаг, орж эргэлт, техник трюк хувийн бэлтгэлүүд хийгдсэн Эрхэм төрын тамгат баатарууд тоглолтын бүжгүүдийн бэлтгэл сургуулилт бүжгүүдийн тавилт хийсэн. Цэргийн андууд хүндэтгэлийн тоглолтонд оролцох МУСТА Ё.Дамчаабадгарын дэглэлт **“Хадын орой”** болон Цэргийн дуу бүжгийн бүжигчидтэй нийлсэн **“Мөрдөс нэгт”** бүжгийг заалгаж нэгдсэн сургуулилт хийсэн. Мөн Мөнгөнцэцэг багшийн 16 тоот биелгээ дасгалыг сурсан. Мэргэжлийн дасгалууд 14 удаагийн 28 цагийн Сонгодог бүжгийн дасгал, 8 удаагийн 16 цагийн Иогийн дасгал, 7 удаагийн 14 цагийн Монгол бүжгийн дасгал. Нийт 29 удаагийн дасгал 58 цагт хийж гүйцэтгэсэн байна.

Шинээр дараах бүжгүүдийг хийсэн:

Жаргалтай гэр бүл дуун дээрх бүжиг

Хадын орой

Барайгаад нүүсэн нүүдэл

Хур бороо

Үл тасрах бүүвэй

Алтайн ятга

Дуучин Т.Ариунаагийн “Хайраар бүтээдэг” дуун дээрх бүжиг

Тик Ток

МУГЖ Б.Цэвэлмаагийн “Сүлдэнд мөнхөрсөн дуулал-3” уран бүтээлийн тоглолтод ардын дуу Хүрэн морь, Хоёр сэтгэл, Амрагийн дуу, Хаврын шөнийн бодол, Монгол төрийн цагдаа, Аминаас үнэтэй тангараг, Би Монгол хүн зэрэг дууны бэлтгэл сургуулилтыг хийж тоглосон. Ардын дуу Хоёр сэтгэл, Сэтгэлийн дуу зэрэг дуунуудын хөгжмийн найруулга хийсэн

Хөгжмийн найруулагч Ж.Отгончулуун нь Хамгаалан сахисан голомт, Зүүдэнд уяатай аав, Хаадын зарлигтай Монгол нутаг, Ёохор хатарыш, Ижий минь бодогдоно дуунуудын хөгжмийн найруулгыг хийж ажилласан.

2023 оны эхний хагас жилд цагдаа, дотоодын цэргийн анги байгууллага, алба хаагчид, ард иргэдэд давхардсан тоогоор 165 тоглолт, ёслолын арга хэмжээнд оролцсон байна.

- Хөгжмийн хэсэг нь 80 тоглолт
- Дууны хэсэг 62 тоглолт
- Бүжгийн хэсэг 23 тоглолтод оролцсон.

Үүнд:

- 2022 он: XII/23 ЦДЦБ-ын алба хаагчдад шагнал гардуулах ёслолын арга хэмжээ
- XII/26 Дотоодын цэргийн штабын 2022 оны үйл ажиллагааны тайлангийн хурал
- XII/26 Чингэлтэй дүүрэг дэх ЦГ-ын 2022 оны үйл ажиллагааны тайлангийн хурал
- XII/27 НЦУГ-ын 2022 оны үйл ажиллагааны тайлангийн хурал /Corporate/
- XII/28 Батсүмбэрийн ахмадын асрамжийн газрын шинэ жилийн арга хэмжээ
- XII/29 ЦЕГ-ын Автобаазын ахмад настан Ж.Нацагт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ
- 2023 он: I/05 ОХУ-ын Улаан-Үдэ хотод консулаар ажиллах бригадын генерал М.Ганхүү, Буриад улсын зочдод зориулсан тоглолт /Их танхим/
- I/19 ЦДЦБ-ын Удирдах ажилтны 2023 оны сургалт, зөвлөгөөний нээлт /Corporate/
- I/20 ЦДЦБ-ын Удирдах ажилтны 2023 оны сургалт, зөвлөгөөний оройн зоогийн арга хэмжээ /Corporate/
- I/25 Төмөр зам дахь ЦГ-ын дэргэдэх Ахмадын зөвлөлийн өдөрлөг
- II/03 “Хамтдаа бүтээсэн 70 жил Ахмад, дунд, залуу үеийн уулзалт зөвлөгөөн” II/04 МУ-ын Аж Үйлдвэрийн Гавьяат Ажилтан Доржрэнчингийн цолны мялаалга
- II/09 “Шүүх шинжилгээний тухай хууль”-ийн эх бичвэрийг хүлээн авах ёслолын арга хэмжээ
- II/14 Цагдаа мюзикл түүрвix найруулагчид зориулсан тоглолт
- II/24 ЦЕГ-ын Сар шинийн золголт
- II/24 МДШШУА-ны Сар шинийн золголт
- II/24 Сар шинийн золголт
- III/04 БЗД Биеийн тамир спортын анхдугаар уралдааны нээлт
- III/05 МУГЖ Б.Цэвэлмаагийн “Сүлдэнд мөнхөрсөн дуулал-3” уран бүтээлийн тоглолт
- III/07 ЦЕГ-ын харьяа газар, хэлтэс, нэгжийн эмэгтэй алба хаагчдад зориулсан тоглолт
- III/11 МУ-ын Гавьяат хуульч Т.Ганбаатар цолны мялаалга
- III/14 МУ-ын ерөнхийлөгчийн “Цэргийн андууд” дурсамж уулзалт
- III/15 МУ-ын ерөнхийлөгчийн “Цэргийн андууд” дурсамж уулзалт
- III/16 ЦЕГ Шагнал гардуулах арга хэмжээ
- III/18 ЗХ-ны 102 жилийн ойд зориулсан “Эх орны төлөө” мөрдэст чуулгуудын нэгдсэн хүндэтгэлийн тоглолт
- III/23 НХЖХОНАБХА-ны Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээ
- III/24-IV/02 “Bravo II circus” Олон улсын циркийн тоглолт /18 удаа/
- III/29 “Эрхэм төрийн тамгат баатрууд” түүхэн дууль
- IV/07 Оршуулгын арга хэмжээ

- IV/10-15 Цагдаагийн албаны болон Дотоодын цэргийн байлдааны туг цэнгүүлэх ёслолын арга хэмжээ /Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг, Багануур дүүрэг/
 - IV/17 Ахмадын танхимийн нээлтийн арга хэмжээ
 - IV/17-20 Цагдаагийн албаны болон Дотоодын цэргийн байлдааны туг цэнгүүлэх ёслолын арга хэмжээ /Төв, Дундговь, Өмнөговь аймаг/
 - IV/25 Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын 2023 оны Эрүүгийн цагдаагийн албаны нэрэмжит “Дартс”-ын аварга шалгаруулах тэмцээний нээлт
 - IV/27 МУ-д Генерал цол би болсны 79 жилийн ой, ЦДЦБ-ын Генералуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ
 - IV/28 ЦБ-д Дотоод хяналт аюулгүй байдлыг нэгж үүссэний 30 жилийн ойд зориулсан тоглолт
 - IV/28 Төв аймаг дахь Цагдаагийн газрын 80 жилийн ойн хүндэтгэлийн тоглолт
 - V/01-05 Цагдаагийн албаны болон Дотоодын цэргийн байлдааны туг цэнгүүлэх ёслолын арга хэмжээ /Дорноговь, Говьсүмбэр аймаг, Багахангай дүүрэг, Налайх дүүрэг/
 - V/08-14 Цагдаагийн албаны болон Дотоодын цэргийн байлдааны туг цэнгүүлэх ёслолын арга хэмжээ /Эрдэнэт, Дархан, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл/
 - V/11 ЦЕГ-ын Зөрчлийн хэрэг бүртгэх газрын “Ширээний теннис”-ийн аварга шалгаруулах тэмцээн
 - V/18 Олон улсын музейн өдөрлөгийн нээлт
 - V/17-30 Цагдаагийн албаны болон Дотоодын цэргийн байлдааны туг цэнгүүлэх ёслолын арга хэмжээ /Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Увс, Баян-Өлгий, Завхан, Архангай/
 - VI/01 ЦДЦБ-ын алба хаагчдын хүүхдүүдэд зориулсан “Хүүхэд таныг хамгаалъя” өдөрлөг
- VI/03 БЗД-ын Прокурор, Цагдаагийн газрын хамтарсан спортын 6 төрөлт наадам

III/24-IV/02-ны өдрүүдэд хөгжимчид “Bravo II circus” Олон улсын циркийн тоглолтод Франц, Хятад, ОХУ, Беларусь, Молдав, Казахстан, Киргиз, Перу, Чили, Монгол улсын циркийн жүжигчидтэй хамтарсан тоглолтод оролцож 18 удаа тоглосон.

Үлээвэр найрал хөгжим, дуучид 4, 5 дугаар саруудад Цагдаагийн албаны болон Дотоодын цэргийн байлдааны туг цэнгүүлэх ёслолын арга хэмжээг 21 аймаг, 3 дүүрэгт зохион байгуулж ажилласан.

Чуулгын нэгдсэн болон хэсэгчилсэн 54 тоглолтыг цахим архивын Hard disk-нд 1 хувь, DVD-нд 2 хувь хуулбарлаж цахим санд оруулсан. Үүнд:

- Монгол улсын Төрийн дуулал Сүлд чуулга
- Орчин цагийн Цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүндэтгэлийн тоглолт
- Royal arte хамтлагийн тоглолт
- Онгод хамтлагийн тоглолт
- Цагдаагийн байгууллагын 96 жилийн ой теле концерт
- “Цагаан сар” 2022 цэнгээнт нэвтрүүлэг /2022 он/
- “Энх мэндийн хадаг” теле концерт /2018 он/
- Монгол минь амгалан байна /2020 он/
- Үргэлж тантай хамтдаа тоглолт /2018 он/

- Түүх мартаггүй кино концерт /2021 он/
- Цагаан шонхор аннимейшн
- СТА У.Батбаяр “Чандмань тамга” тайлан тоглолт
- Цагдаагийн байгууллагын 101, Дотоодын цэргийн 100 жилийн ойн хүндэтгэлийн тоглолт
- “Эрхэм төрийн тамгат баатрууд” түүхэн дууль
- Халил бүжгийн тоглолт
- Шинэ сарын аялгуу теле концерт
- Эгшиг амилах цэнгүүн үлээвэр найрал хөгжмийн тоглолт
- Цэрэг ёсоор үүрэг биелүүлснийг илтгэе тоглолт
- Сүлд чуулга 2017.12.31 тоглолт /1-р хэсэг/
- Дуулан дуулан ирлээ
- Монгол түмний сондор аялгуу
- Аягтай Аястай хорвоо теле концерт СТА Ц.Амарболд
- “Сүлжээ гурван аялгуу” концерт MNB С.Дуламсүрэн
- Торгоны хээ дүүчин Б.Долгормаа
- Монгол минь амгалан байна 2019.07.17

Сүлд чуулга 2021 цахим тоглолт

- “Эх орны төлөө” мөрдэст чуулгуудын тоглолт
- Великая Победа 2020 тоглолт
- Үргэлж тантай хамтдаа өдөрлөг 2017-2019 он
- Өвөрхангай аймаг дах Цагдаагийн газрын 80 жил ой
- “Далд авъяас” Сүлд чуулгын алба хаагчдын тоглолт
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь бүх нийтийн үйлс
- Залуу нас тоглолт 2012.12.05
- Инээмсэглэл гийсэн залуу нас 2013 шинэ жилийн цэнгүүн
- Сүлд чуулга 2012.10.26
- Сүлд чуулга Сэлэнгэ аян замын тэмдэглэл 2013
- Сүлд чуулга тоглолт 2012.03.23
- Сүлд чуулга тоглолт 2012.10.30
- Сэтгэлд хүрэх замд 2013 цомог
- Цагаан шонхорын тэмүүлэл бүжигчдийн тоглолт
- TV8 телевиз /Эгшиг амилсан залуу нас, ҮНХ тоглолт/
- Цэнгэл дүүрэн цагаан сар теле концерт зэрэг **Нийт 54 тоглолтын бичлэг.**

Цагдаагийн Сүлд чуулгын нотны урын санг цахимжуулах ажлын хүрээнд нотны урын санд ангилан ялгалт хийж хөгжмийн бүтээлийн партитур, нотын хамт бүрдүүлэн 9 хавтасанд хийж жагсаалт гаргаж нотыг цаасаар болон цахим файлаар хадгалсан. Зарим дутуу нотыг шивэж бүрдүүлсэн. Үүнд:

1. Маршийн хөгжмийн уран бүтээл №1 /14 бүтээл/
2. Маршийн хөгжмийн уран бүтээл №2 /25 бүтээл/
3. Бүжгийн хөгжмийн бүтээл /14 бүтээл/
4. Цагдаагийн 100 ойн хүндэтгэлийн тоглолт /14 бүтээл/
5. Монгол хөгжмийн бүтээл /19 бүтээл/

6. Монгол дууны бүтээл №1 /28 бүтээл/
 7. Монгол дууны бүтээл №2 /28 бүтээл/
 8. Гадаад хөгжмийн бүтээл №1 /28 бүтээл/
- Гадаад хөгжмийн бүтээл №2 /28 бүтээл/

Нийт 198 бүтээл.

ЦДЦБ-ын алба хаагчдын хүүхдүүдэд зориулсан “Хүүхэд таныг хамгаалъя” өдөрлөгийн тоглолтын хөтөлбөр, тоглолтод урилгаар оролцох уран бүтээлчдийн нэрсийг боловсруулж танилцуулсан. Уран бүтээлчид тус арга хэмжээнд “Нарны хаан хүүхдүүд”, “Жаргалтай гэр бүл”, Тик Ток бүжиг, Хүүхдийн дууны эвлүүлэг, Поророгийн найзууд киноны хөгжмийн бүтээлийг тоглож амжилттай оролцсон.

МУУГЗ, нэрт бүжиг дэглээч Д.Санжаасүрэн агсны нэрэмжит мэргэжлийн гоцлол болон цөөхүүл бүжигчидийн улсын анхдугаар уралдаанд оролцон бүжигчин цагдаагийн дэд ахлагч С. Хишигдүүрэн, Д.Долгормаа, Э.Халиун нар цөөхүүл төрөлд “ДЭД БАЙР”, бүжигчин Цагдаагийн дэслэгч А.Эрдэнэбаяр гоцлол төрөлд “ТУСГАЙ БАЙР” тус тус эзэлсэн.

Монголын шинэ үеийн дуу, хөгжмийг үндэслэгч Магсархурцын Дугаржавын мэндэлсний 130 жилийн ойд зориулан түүний зохиосон дууны уралдаанд тус чуулгын уртын дуучин, цагдаагийн ахлагч Л.Эрдэнэболд амжилттай оролцож “Тусгай” байр эзэлсэн.

Хөгжмийн найруулагч Ж.Отгончулуун нь “Сэрсэн тал хөгжмийн бүтээл”, “Хамгаалан сахисан голомт”, “Зүүдэнд уяатай аав”, “Хаадын зарлигтай Монгол нутаг”, “Ёохор хатарыш”, “Ижий минь бодогдоно” зэрэг дуунуудын хөгжмийн найруулгыг хийж ажилласан.

Арав. Цагдаагийн музейн үйл ажиллагааны талаар

Тус чуулгаас Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны 2023 оны сургалт, зөвлөгөөний үеэр удирдах ажилтнуудад Чингис хаан үндэсний музей үзүүлэх ажлын хүрээнд төв, орон нутгийн цагдаа, дотоодын цэргийн 56 байгууллагаас ирүүлсэн нэрсийн дагуу 189 удирдах ажилтныг 3 хэсэгт хуваарилсан хуваарь, хөтөлбөрийг ЦЕГ-ын Дэд даргад 25/717 дугаартай албан бичгээр хүргүүлж батлуулсан. 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 13.00-18.00 цагт сургалт, зөвлөгөөнд оролцож буй удирдах ажилтнууд заасан цагт хуваарьтай хэсэгтээ бүртгүүлэн чип /гэрэг/-ээ хүлээн авч, тус музейн эрдэм шинжилгээний ажилтан 1, тайлбарлагч 1, чуулгын 1 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй баг нь музейн 3-8 давхарын үзүүлэгийн танхимаар үйлчилгээ үзүүлэв. Үзвэрийн дараа музейн захирал, академич С.Чулууны лекцэд хамрагдсан. Батлагдсан нэрсээр 188 удирдах ажилтнууд үзвэр үзэхээс 29 удирдах ажилтан ажлын шаардлагаар музей үзээгүй бөгөөд чип /гэрэг/-ийг буцаан олгов.

МУ-ын Ерөнхийлөгчийн санаачлагаар 5 дахь жилдээ зохиож буй “**ЦЭРГИЙН АНДУУД**” дурсамж уулзалт, хүндэтгэлийн арга хэмжээ 2023 оны 03 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдсан. Арга хэмжээнд цагдаагийн музейгээс 3 хэсэг үзмэр, эд зүйлсийг дэлгэн үзүүлж, VR музейгээр нийт 96 ахмад ажилтнуудад үйлчиллээ.

Олон Улсын Музейн зөвлөлийн Монгол дахь Үндэсний хорооны 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн хүрээнд ICOM MONGOLIA, МУ-ын Соёлын яам, Чингис хаан Үндэсний музей, Чойжин ламын музейтэй хамтран 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Чингис хаан Үндэсний музейд Олон Улсын Музейн өдрийг тэмдэглэн өнгөрүүлээ. Тус чуулгаас “Музейн тогтвортой байдал ба сайн сайхны төлөө” сэдэвт ОУ-ын музейн өдрийн нээлтийн арга хэмжээг хөтлөн урлагийн

хэсэгчилсэн тоглолтыг толилуулж, эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлэгт амжилттай оролцов.

Чуулгаас зохион байгуулах соён гэгээрүүлэх ажлын хүрээнд алба хаагчдаас “Чингис хаан Үндэсний музейг үзэх” хүсэлт гаргасаны дагуу чуулгын 32 алба хаагч, ажилтнуудыг “Чингис хаан Үндэсний музей”-г үнэ төлбөргүй үзүүлэх ажлыг зохион байгуулсан.

2023 оны эхний хагас жилд тус музейгээр ОХУ-ын төлөөлөгч зочин 13, ОУ-ын Эмэгтэйчүүдийн холбооны ажилтан 6, Соёлын яамны харьяа Соёл урлагийн менежер залуучууд хөгжлийн төвийн менежер 7, чуулгад ажил хэргийн шугамаар ирсэн зочин 6, “Цэргийн андууд” дурсамж уулзалтад оролцсон ахмад ажилтан 96, Төв цэнгэлдэх хүрээлэнд зохиогдсон Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт оролцсон 61 хүүхэд, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгээс ирүүлсэн хүсэлтээр алба хаагч 17, хүүхэд 47, ЦЕГ-ын ДХАБХ-ийн алба хаагчийн гэр бүлийн гишүүн хүүхэд 25, ДХИС-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу I дамжааны 20 сонсогч, II дамжааны 11 сонсогч, энгийн иргэн 14, ахмад ажилтан 6, алба хаагчдын гэр бүл 2, хүүхэд 6, ЕБС-ийн 3 хүүхэд, ОХУ-ын иргэн И.П.Сонька, 1995 онд албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан хэв журмын цагдаа Ж.Амаржаргалын охин, 3 зээгийн хамт, тус чуулгад шинээр томилогдсон 9, нийт **354** /алба хаагч 26, гэр бүлийн гишүүд 3, ахмад ажилтан 102, иргэд 47, хүүхэд залуучууд 145/ хүн үйлчлүүлсэн.

Дэглэлт, тохижилтын талаар:

“Түүхэн замнал” танхим

Цагдаагийн байгууллагын “Байлдааны гавьяаны улаан түгийн одон”, “Сүхбаатарын одон”-г захиалан хийлгэж, одонгоор шагнагдсан тухай зарлигийг 50х30 хэмжээтэй хэвлүүлж, лед гэрэл холбож гэрэлтүүлэгтэй болгосон.

Үүдний танхимын хананд 2х1.5 хэмжээтэй чулуун хавтан байрлуулж, “Цагдаагийн музей” гэсэн бичвэрийн 17 үсэг, тэмдэгтийг алтан шаргал акрилиар “Алтан бэрс” ХХК-д эмжээр булан, 1.5х1.5 хэмжээтэй цагдаа логог Юнипресс ХХК-д тус тус захиалж хийлгэсэн.

Иргэн Ш.Пүрэвдоржтой “Ажил гүйцэтгүүлэх гэрээ” байгуулж, музейн 3 дугаар давхарын 12 ширхэг витерины гэрлийн хаалтыг UV материалаар модон рам зангидан бүрж тогтоов.

Эрүүгийн цагдаагийн албаны 90 жилийн ой тохиохтой холбогдуулан тус албанаас цагдаагийн музейд Алдар хүндэтгэлийн танхим байгуулж өгөх ажлыг эхлүүлэв.

“Бид мартаггүй” танхим

“Бид мартаггүй” хөшөөний ард тэнгэрийн дүрс бүхий 4.6х2.1 хэмжээтэй стикер хэвлүүлэн нааж, хөшөөний ард байрлуулах ёсолж буй цагдаагийн дүрс бүхий хавтанг Юнипресс ХХК-д захиалж хийлгэв.

Музейн сан хөмрөгийг баяжуулах чиглэлээр:

Музейд “Сүлд” чуулгын булан байгуулахад эд зүйлс цуглуулах зорилгоор МУСГЗ, цагдаагийн хурандаа Л.Гаваасүрэнгийн гэр бүл, МУГЖ, цагдаагийн хошууч Г.Ариунбаатар нарт “Музейд ирүүлэх эд зүйлсийн жагсаалт”-ыг хүргүүлэв. Л.Гаваасүрэн агсны гэр бүлээс 87 ширхэг эд зүйлс хүлээн авч зохих журмын дагуу бүртгэлжүүлэв. Г.Ариунбаатар нь гадаад улсад ажиллаж амьдарч байгаа тул өөрийн биеэр Монгол улсад ирэх үедээ өөрийн эд зүйлсийн хуулбарыг өгөхөөр тохиролцов.

Хадгалалт, хамгаалалтын талаар:

Виртуал төхөөрөмжид суулгасан контентуудын бүрэн бүтэн байдалд үзлэг, шалгалт хийж, виртуал төхөөрөмжүүд, гар удирдлагын дугааруудыг шинээр хэвлүүлж наасан.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг зохион байгуулахтай холбогдуулан 2023.04.01-ний өдрөөс эхлэн музейн үзмэр, эд зүйлсийг данс бүртгэлтэй тулгаж, бүртгэлгүй зүйлсийг бүртгэлжүүлж, жилийн эцсийн тооллоготой холбогдуулан музейн 4 дүгээр давхар /чирдак/-ын өрөөнд байгаа эд зүйлсийг няравын бүртгэлтэй тулган тоолж, цэвэрлэгээ үйлчилгээ хийв.

Бусад ажил:

ЦЕГ-ын Тусгай ажиллагааны газраас виртуал музейн контентуудыг үзэн танилцаж өөрийн байгууллагын болон бусад цагдаагийн албадын контентуудыг хуулбарлаж авах тухай хүсэлтийг ирүүлсэн. Удирдлагын шийдвэрийг хүлээж байна.

“Бахархал” танхимын үзмэрүүдийн тайлбарыг монголоос англи хэлээр хөрвүүлж, 29 ширхэг тайлбарыг шинэчлэв.

МУ-ын Соёлын яамнаас энэ жил 14 дэх удаагаа зохион байгуулж буй оны шилдэг уран бүтээл, уран бүтээлчийг шалгаруулах “Мөнгөн мод-2022” уралдаанд “Сүлд” виртуал музейгээр оролцов.

Музейн 5000 төгрөгийн үнэ бүхий 180 ширхэг үзвэрийн тасалбарыг хэвлүүлсэн бөгөөд ШШҮХ-ийн 17 алба хаагчийн тасалбарын үнэ болох 85000 төгрөгийг төрийн сангийн дансанд байршуулж, орлогыг төвлөрүүлэв.

Цагдаагийн төв архивт “цагдаагийн түүх судлаач”-аар ажиллаж байгаад цэргийн байнгын тэтгэвэрт гарсан ахмад ажилтан, цагдаагийн бэлтгэл хурандаа Гүндсамбуугийн Төмөрбаатар гуайг урин музей үзүүлж, музейн үзүүлэг дэглэлттэй холбоотой асуудлаар зөвлөгөө авч, цагдаагийн түүх судлалын чиглэлээр хамтран ажиллаж байна.

Тус музейн “Бахархан дууриах үйлстнүүд” алдрын танхимд байрших хошууч генерал А.Думбурайн эд зүйлсийг түүний охин Д.Дунгармаа үзэх хүсэлтээ гарган “Дотоодын цэргийн 805 дугаар ангийг хошууч генерал А.Думбурайн нэрэмжит болгож байгаа”-тай холбогдуулан аавынхаа одон медаль, хувцас, шагналуудтай танилцаж, данс бүртгэлтэй тулган үзэж, гэр бүлийн зургаа авах хүсэлтээ илэрхийлсэн тул хуулбарлан авах боломжоор хангасан.

Арван нэг. Санхүү, бүртгэл, хангамж,
үйлчилгээний талаар

Санхүүгийн тайлангаар Сүлд чуулгын 2023 оны 06-р сарын 09-ны өдрийн байдлаар санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна.

Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2023 оны 06-р сарын 09-ны өдрийн байдлаар төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг ахлах нягтлан бодогч 2023 оны 06-р сарын 30-ны дотор бэлтгэж, 2023 оны 07 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Санхүү аж ахуйн албанд хүргүүлнэ.

Санхүүгийн тайлагналын хугацаа нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 2023 оны 06-р сарын 30-ээр дуусгавар болсон байна.

Тус байгууллагад 2023 оны 06-р сарын 09-ны өдрийн байдлаар улсын төсвөөс 711,4 сая төгрөг, өөрийн орлого 16,3 сая төгрөг нийт 727,7 сая төгрөгийн төсөв батлагдснаас гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилт 711,4 сая төгрөг, өөрийн орлогоор 17,8 сая төгрөг төсөвт төвлөрүүлж бүгд 729,2 сая төгрөгийн эх үүсвэртэй ажиллаа.

Цагдаагийн байгууллага нь үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулахад бараа материалын зүйлсийг ашигладаг. Санхүүгийн тайланд тусгагдсан Бараа материал дансны эцсийн үлдэгдэл нь байгууллагын эзэмшилд бодитойгоор байгаа бүх бараа материалын зүйлсийг багтаасан.

Тус байгууллага нь бараа материалыг орлогод авах, зарцуулах буюу байгууллагын хэрэгцээнд тавьж олгохдоо бараа материалын байнгын системийг ашигласан болно. Байнгын системийн дагуу бараа материалын орлого ба зарлагын хөдөлгөөн өртгийг тухайн ажил гүйлгээ гарсан өдөр бүр тооцоолж бүртгэлийг хөтлөв.

Бараа материалын зарцуулалтыг тооцож бүртгэлд тусгахдаа эхэлж авсныг эхэлж зарлагдах аргыг хэрэглэсэн.

2023 оны 06 сарын 09-ны өдрийн байдлаар цалин хөлсд 526,4 сая төгрөг, ажил олгогчоос 16,3 сая төгрөг, тогтмол зардалд /оснаауг, цахилгаан, цэвэр бохир ус/ 20,3 сая төгрөг, бичиг хэргийн материалд /бичгийн цаас, фото цаас, принтерийн хор г.м/ 1,3 сая төгрөг, аж ахуйн материалд /оо-ийн цаас, саван, вок, алчуур г.м/ 822,5 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 342,3 мянга, чуулгын засвар үйлчилгээний зардал, гэрэл чийдэн, сангийн материал г.м/ 4,3 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд /сургалтын материал, гарын авлага, бэлэг дурсгал г.м/ 360 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж нийт 2 алба хаагчдад 117,7 сая төгрөгийн зардалуудыг зохих журмын дагуу цохолтоор зарцуулагдаж мөн 04-р сарын дундаас finance.gov.mn-ны цахим санхүүгийн программаар гүйлгээ хийгдэж эхэлсэн.

➤ Гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгэдэг үйлчлэгч, слесарь, цахилгаанчин нарт сар бүр илүү цагаар ажилласан тооцоог гаргаж цалингийн нэмэгдлийн тогтмол олгуулж байна. Чуулгын байрны гадна цэвэрлэгээг тогтмол 7 хоногт 2 удаа хийлгэж ажиллаж байна.

➤ Чуулгын байрны дотор болон гадна цэвэрлэгээг үйлчлэгч нараар өдөр бүр ариутгалын бодис болон 70%-ийн уусмалтай спиртэн цэвэрлэгээг тогтмол хийлгүүлж цэвэр цэмцгэр байдлыг хангаж ажиллаж байна.

➤ Чуулгад гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгэдэг цахилгаанчин, слесарь, үйлчлэгч нарыг өдөр тутмын удирдлагаар хангаж хөдөлмөр аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр тутам өгч ажиллаж байна.

➤ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 429 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын стандарт”-ын хэрэгжилтийг дагуу барилга байгууламжийн хувийн хэргийг хөтлөж баяжилтийг тухай бүрт хийж байна.

➤ Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд байрны телехяналтын камерын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахад хяналтын камерын засвар үйлчилгээг тухай бүрт нь тогтмол хийж ажиллаж байна.

➤ Чуулгын байранд хийгдэх засварын ажлын төсвийг тухай бүрт нь хийж чуулгын даргаар батлуулсан.

➤ Дээд байгууллага болон харьяа байгууллагаас ирсэн хугацаатай албан бичгийн хариуг тухай бүрт явуулж байсан.

➤ Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд байрны телехяналтын камерын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахад хяналтын камерын засвар үйлчилгээг тухай бүрт нь тогтмол хийж ажиллаж байна.

➤ Мөн байгууллагын www.suld.police.gov.mn сайтад соёл урлаг санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, үйл ажиллагаа, тушаал, шийдвэр, видеоны мэдээний баяжуулалтыг тухай бүрт нь хийсэн. Мөн авилгатай тэмцэх газрын <https://iaac.mn/> сайт, улсын шилэн дансны www.shilendans.gov.mn сайтыг холбож ажилласан.

Сүлд чуулгаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн болон халагдсан 5 алба хаагчийн дүрэмт хувцас, хэрэглэлийн төлбөр 4,249,660 төгрөгийг бүрэн барагдуулж төлбөрийн үлдэгдэлгүй ажиллаж байна.

Арван хоёр. Алба хаагчдын нийгмийн асуудал,
үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний
талаар

Алба хаагчдыг албан үүргээ гүйцэтгэх нөхцлөөр хангах зорилготой тус чуулгын тоглолтын зааланд 2.000.000 төгрөгний тайзны гэрэлтүүлгийг байгууллагын урсгал зардлаас гаргаж хийсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас 2023 оны 05 дугаар сард Dell маркийн 1 ширхэг /иж бүрэн/ компьютерийг хүлээн авч бичиг хэргийн эрхлэгч, архивчид олгосон.

“Эрт илрүүлэг”-ийн үзлэг шинжилгээнд 64 алба хаагч, ажилтан хамрагдахаас 38 алба хаагч, ажилтан бүрэн хамрагдаж, 16 алба хаагч, ажилтан хамрагдаад явж байна, үлдсэн 10 алба хаагчийг хамруулах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.

Тус чуулгын алба хаагч, ажилчдын “Дундын сан”-аас 2023 оны эхний хагас жилийн байдлаар “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан 0-16 насны 73 хүүхдэд нийт 1.554.900 төгрөгний гарын бэлэг;

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 3 алба хаагч тус бүрт эргэлтийн 50000 төгрөг;

Ар гэрийн гачигдал гарсан 1 алба хаагчийн ар гэрт 500.000 төгрөгний хандив;

Шинэ хүүхэд мэндэлсэн 3 алба хаагчийн хүүхдэд тус бүрт 100.000 төгрөгийг;

Цэргийн алба хаасны, өндөр насны тэтгэвэрт гарсан нийт 4 алба хаагч тус бүрт 100.000 төгрөгийг бэлнээр өгсөн байна.

Арван гурав. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам
хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах
болон эргүүл, хяналт шалгалтын талаар

2023 оны төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас авлигын индексийг бууруулах чиглэлээр хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний хүрээнд Сүлд чуулгаас хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний салбар төлөвлөгөөг тус тус боловсруулан баталгаажуулсан.

Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын ЭБАТ-ийн ажил үүргийн дагуу 17 офицер алба хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг meduuleg.iaас.mn цахим хаягаар бүртгүүлж, баталгаажуулан нотломж /199 хуудас бүхий хадгаламжийн нэгж/-ийг ЦЕГ-ын АБХ-т хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан “Мэдүүлэг гаргагчдад зориулсан гарын авлага”-ыг тараан судлуулж, бие бүрэлдэхүүнд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга, Аюулгүй байдлын хэлтсээс ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлүүдийг тухай бүр танилцуулж иргэн хуулийн этгээдээс бэлэг, хандив, санхүүгийн туслалцаа авах асуудлаар хуульд заасан хориглолт, хязгаарлалтын хэмжээнд ажиллаж буй эсэхэд байнгын хяналт тавьж, алба хаагчдыг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлига, ашиг сонирхлоос ангид байх чиглэлээр офицер бүрэлдэхүүнээс 6, ахлагч бүрэлдэхүүнээс 5 заалт бүхий баталгааг тус тус авч ажилласан.

2023 оны 02 дугаар улирлын байдлаар ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл иргэд байгууллагаас ирээгүй болно.

Чуулгын 1 дүгээр давхарт байрлуулах “Авлигаас урьдчилан сэргийлэх мэдээллийн самбар”-т Авлигын эсрэг хууль, тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны материал, гарын авлага, төсвийн гүйцэтгэл, танилцуулга, худалдан авах ажиллагаа, шилэн дансны мэдээллийг шинэчлэн байршуулж ажилласан байна.

Арван дөрөв. Цаашид хэрэгжүүлэх ажил,
арга хэмжээний талаар

1. Чуулгын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний явцыг үнэлж, 3 дугаар улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх.
2. Буриад улсад хийх тоглолтын хөтөлбөр гаргаж, шинэ уран бүтээл туурвих, уран бүтээлчдийг тоглолтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах
3. Алба хаагчдын эрүүл мэнд сэтгэл зүйг дэмжих “Үргэлж тантай хамтдаа” соён гэгээрүүлэх цогц арга хэмжээг 5 доошгүй аймагт зохион байгуулах.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН СҮЛД ЧУУЛГА